

“МОНГОЛ ХЭЛ” ХИЧЭЭЛИЙН ДААЛГАВАР

САНАМЖ : Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй.

Модоо хамгаалсан нь

Эрт цагт цулгуй газрын хөрсөнд анх ногоо ургажээ. Дараа нь уулын араар цөөхөн мод ургав. Мод ч олшрон ургасаар ой болж олон төрлийн шувууд нутагшжээ. Гэтэл олон нарс шарлан хатчихаж гэнэ. Модондоо хайртай шувууд гайхан ажиглавааас түүний нь үй түмэн өт хорхой идэж сүйтгэж байлаа. Хамаг шувууд мод юугаа хамгаалахаар хүч үзэлцэн тэмцэв. Далавчаараа алгадах нь алгадаж, зарим нь савраараа базаж олонхыг нь устгажээ.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: УНШИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

1.1. Хамгийн анх газрын хөрсөнд юу ургасан бэ?

а. мод б. ногоо в. хүнсний ногоо

1.2. Шувууд хаана ирж нутагшсан бэ?

а. ууланд б. цулгуй газарт в. ойд

1.3. Ой модыг хэн сүйтгэсэн бэ?

а. өт хорхой б. хүмүүс в. шувууд

1.4. “Далавчаараа” гэсэн үгийг үеэр зөв заагласан хэсгийг олоорой.

а. да-лав-чаа-раа б. дал-авч-аар-аа в. далав-чаа-раа

1.5. Хэн? ямар? юу? яав? Гэсэн асуултад тохирох өгүүлбэрийг олоорой.

а. Ах хоёр чулуу түүв. б. Аав шинэ машин авав. в. Дүү надад ном өгөв.

ХОЁРДУГААР ХЭСЭГ: БИЧИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

2.1. Ямар мод шарлан хатсан бэ?

.....

2.2. “Ий, ы” залгаврыг зөв залган бичээрэй.

Тогооч.....н шанага, үлгэр.....н ном, чихр.....н таваг, багш.....н цүнх

2.3 Эхээс асуултад тохирох үгийг олж холбоо үг үүсгээрэй. /2 оноо/

Ямар? Нарс-.....

Өт хорхой яаж?-.....

Далавчаараа яах?-.....

Ногоо яажээ?-.....

2.4 Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй. /бага, баг, сана, сан/ /1 оноо/

Манайх долоо дугаарт амьдардаг.

Манай ангийнхан өнөөдөр номынд ном уншив.

2.5 Үгсийг утгаар нь холбоорой.

Ногоо	ниснэ.
Нар	урсана.
Шувуу	хөөрнө.
Ус	нүүнэ.
Үүл	ургана